

**ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1-д “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.” гэж, 4.1.3-т “Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1-д “Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 75 дугаарт Монгол Улсын Засгийн газар Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг санаачлан боловсруулахаар тусгасан.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу зохицуулах бөгөөд мөн хуульд заасны дагуу хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас баталсан аргачлалуудын дагуу зохих тандан судалгаа, эсхүл үнэлгээг хийсний үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэн найруулах эсэхийг шийдвэрлэхээр заасан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Монгол Улсын Засгийн газраас Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтад заасны дагуу 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтад заасны дагуу “хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох” зорилгод үндэслэн хийсэн болно.

- оОо -

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийх ажлын зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуульд 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг шинээр нэмж, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалууд хамаарахгүй байх нийт 24 тохиолдлыг тоочин заасан. Мөн аргачлалын 1.3 дахь хэсэгт энэхүү аргачлал хамаарахгүй буюу аргачлалын дагуу үнэлгээ хийх шаардлагагүй 5 тохиолдлыг тоочин заасан бөгөөд Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь дээрх тохиолдлуудын алинд ч хамаарахгүй байх тул аргачлалын дараагийн хэсгүүдэд заасны дагуу үнэлгээг үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

- оОо -

ХОЁР. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

Аргачлалын 2.1 дэх хэсэгт заасны дагуу үнэлгээ хийх ажиллагаа нь 3 үе шаттай байна:

- 1.төлөвлөх;
- 2.хэрэгжүүлэх;
- 3.үнэлэх.

Мөн аргачлалын 3.1 дэх хэсэгт заасны дагуу дээр заасан төлөвлөх үе шатанд:

- 1.үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2.үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 3.шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 4.харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5.шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- 6.мэдээлэл цуглуулах аргыг сонгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсний дагуу дээр дурдсан арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн болно.

2.1.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ

Цахим гарын үсгийн тухай хууль нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, хуулийн ямар зохицуулалт практикт хэрэгжиж байгаа, ямар зохицуулалт огт хэрэгжихгүй байгаа талаар судлан үзэж, хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохыг зорилоо.

Дэлхийн улс орнуудад тоон гарын үсгийг хэрэглэх асуудлыг 1990 оноос эхлэн хуульчлан өгсөн байна. Харин манай улсын хувьд 2011 оныг хүртэл цахим гарын үсэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй, нийтийн түлхүүрийн дэд бүтэцгүй байсан нь цахим засаг, цахим бизнес, цахим нийгэм, мэдээллийн технологийн хөгжлөөс хоцорч, олон улсын харилцаанд ижил тэгш оролцох, бусад улстай цахим өгөгдөл солилцох боломжгүй байдлыг бий болгож байна хэмээн 2011 онд цахим гарын үсгийн тухай хуулийг баталж, цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх зүйн үндсийг тогтоож, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна.

Өөрөөр хэлбэл нийтийн түлхүүр ашиглан мэдээллийг шифрлэн хувиргаж, түүнд хамааралтай хувийн түлхүүрээр мэдээллийг задлах, эсрэгээр мэдээллийг хувийн түлхүүрээр шифрлэсэн бол зөвхөн түүнд хамааралтай нийтийн түлхүүрээр задлах зарчмаар ажиллах нийтийн түлхүүрийн дэд бүтцийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын дэргэд байгуулж, иргэн, хуулийн этгээдийг цахим хэлбэрээр таньж, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээг тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд олгодог бөгөөд 2015 онд “Мон Пасс” ХХК, 2018 онд “Тридиум и-Секюрити” ХХК, “ВиЭсЭм” ХХК, “Нью компас” ХХК гэсэн 4 байгууллага Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл авч, нийт 2021 оны 3 сарын эхний байдлаар

30399 тоон гарын үсгийн гэрчилгээг иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. Харин “Үндэсний дата төв” УТҮГ-аас 8008 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээг олгосон хэдий ч одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар тус байгууллагад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх олгогдоогүй байна.

Эрх зүйн орчны хувьд цахим гарын үсэг хэрэглэх боломж нөхцөлийг хуулиар бий болгож өгсөн хэдий ч тус хуулийг баталснаас хойш 9 жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдэд нийт 38407 тоон гарын үсэг олгогдсон байгаа нь практикт тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг бодитойгоор харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр олгосон тоон гарын үсгийн ихэнх нь аж ахуйн нэгж, байгууллагад олгогдож, иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил ихээхэн удаашралтай байгаагаас тоон гарын үсгийн хэрэглээ туйлын хангалтгүй байна.

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоол батлагдаж уг тогтоолоор “...төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх болон Монгол улсын насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийн түлхүүрийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болгох нөхцөлтэй шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан” байна. Гэсэн хэдий ч энэхүү ажлын практик хэрэгжилт хангалтгүй байсаар байна.

Гадаадын улс орнуудын туршлагаас харахад тухайлбал, Европын холбоо 1999 онд “Цахим гарын үсгийн удирдамж”-ийг баталж, 2014 онд зохицуулалтыг шинэчлэн, 2016 оноос холбооны бүх улсуудад хэрэгжиж эхэлсэн “Цахимаар таних болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS No 910/2014)-ын зохицуулалтаар хувь хүн, хуулийн этгээдийг цахим орчинд таних нөхцөлийг бүрдүүлэх, цахим гарын үсэг, цахим тамга, цахим цагийн бүртгэл, цахим баримт бичиг, цахим гүйлгээний журам зэргийг жишиг болгон тогтоож, Европын холбооны гишүүн улс орнууд тоон гарын үсэг хэрэглэхдээ дагаж мөрдөж байна.

Мөн Эстони Улс нь дээр дурдсан Европын холбооноос баталсан журмыг жишиг болгон дагаж мөрдөхөөс гадна 2000 онд баталсан Тоон гарын үсгийн тухай хуулиар тоон гарын үсэгтэй холбоотой харилцааг зохицуулж, хуулийн этгээд бүртгүүлэх, банк, санхүү, сонгууль, татварын бүртгэл хийлгэх зэрэг гарын үсэг шаардаж байгаа аливаа үйлчилгээг төрийн байгууллагаас цахим хэлбэрээр авахад болон бусад үйлчилгээнд 2021 оны байдлаар 900 саяаас дээш тооны тоон гарын үсгийг хэрэглээнд гаргасан гэсэн тоон мэдээлэл байна. Ингэхдээ тоон гарын үсгийг тохиромжтой гэж үзсэн хэрэгсэл буюу иргэний үнэмлэхийн санах ой, гар утасны сим картанд тоон гарын үсгийг байршуулах, Эстони дахь баталгаажсан Smart-ID болон digi-ID зэргийг ашиглан олгодог байна.¹

Цахим гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх асуудал нь иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгохоос эхэлж, одоо үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, хуульд зааснаас дээгүүр болзол, шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж суурь зохицуулалтыг хуульд тусгах, хуулийн бүтцийг илүү ойлгомжтой байдлаар найруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах

¹ <https://e-estonia.com/solutions/e-identity/>

шаардлагатай зүйл, заалт тус бүрт үнэлгээ хийж хуулийг хэрэгжүүлэхэд үүсэж байгаа бэрхшээлийг дурдаж, шийдвэрлэж болох гарцыг тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна.

2.2.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.2 дэх заалтын дагуу үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ.

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хуулийг бүхэлд нь, эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Гэвч хуулийн зохицуулалтыг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал нь хэт өндөр гардаг бөгөөд зөвхөн энэхүү хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатайг харгалзан үзэж дараахь үнэлгээний хүрээг сонголоо.

Үнэлгээний хүрээ 1

Цахим гарын үсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад ориино.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.”

Үнэлгээний хүрээ 2

Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:

“6 дугаар зүйл.Тоон гарын үсгийг хэрэглэх

6.1.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх/-ээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно.”

Үнэлгээний хүрээ 3

Цахим гарын үсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

“7 дугаар зүйл.Тоон гарын үсгийн хэрэгсэл

7.1.Тоон гарын үсэг тухайн тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч этгээдэд хамаарах эсэх болон тухайн цахим баримт бичиг бүрэн бүтэн эсэхийг тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглан шалгана.”

Үнэлгээний хүрээ 4

Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

“8 дугаар зүйл.Тамга орлуулах

8.1.Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ.”

Үнэлгээний хүрээ 5

Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:

“10 дугаар зүйл.Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох

10.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 34.1.5-д заасан журмын дагуу хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/ олгож болно.

17 дугаар зүйл.Гадаад улсын тоон гарын үсгийн гэрчилгээ

17.1.Гадаад улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон гэрчилгээг Монгол Улсад ашиглаж болно.”

Үнэлгээний хүрээ 6

Цахим гарын үсгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

“12 дугаар зүйл.Гэрчилгээний хугацаа

12.1.Гэрчилгээг 2 хүртэл жилийн хугацаагаар олгоно.”

Үнэлгээний хүрээ 7

Цахим гарын үсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

“13 дугаар зүйл.Гэрчилгээг түдгэлзүүлэх

13.1.Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.”

2.3.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОЖ ТОГТООХ

Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийг бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн байх шаардлагатай бөгөөд аргачлалын 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс дээр дурдсан үнэлгээний хүрээн дэх зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байх шаардлагад мөн нийцүүлсэн.

Шалгуур үзүүлэлт 1

Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/

Шалгуур үзүүлэлт 2

Хүлээн зөвшөөрөгдсөн байдал /иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгаа байдал буюу хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэх/

Шалгуур үзүүлэлт 3

Практикт нийцэж байгаа байдал /тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх/

Шалгуур үзүүлэлт 4

Бусад үр дагавар /урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болох/.

2.4.ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭРИЙГ СОНГОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад заасны дагуу хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглана.

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалтад заасан 4-н төрлийн харьцуулах хэлбэрээс тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт харьцуулах хэлбэрийг тохируулж дараахь байдлаар сонголоо:

№	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	Зорилгод хүрсэн түвшин	байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, журам, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль тогтоомжид байвал зохих тодорхой үзүүлэлтийг зааж өгсөн бол тэрхүү үзүүлэлтийг одоо байгаа үзүүлэлттэй шууд харьцуулж болно.

2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.
3	Практикт нийцэж байгаа байдал	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.
4	Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаварууд	тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

2.5.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОМЬЁОЛОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.6.1 дэх заалтад заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлж, эсхүл асуулт тавьж шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар томьёоллоо.

№	Сонгосон шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг томьёолсон байдал
1	Зорилгод хүрсэн түвшин	Уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэн үйлчилсэн эсэх
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудаас хуулийг бүрэн хэрэгжүүлж, иргэд, олон нийт төрийн болон төрийн бус байгууллагаас хуулийг сайн дураараа хэрэгжүүлж байх
3	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
4	Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаварууд	Хууль тогтоогч урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж болзошгүй үр дагаваруудыг тодорхойлох

2.6.МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГЫГ СОНГОХ

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.7.3.1 дэх дэд заалтад заасны дагуу мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистик тоо баримт, гадаад улс орнуудын туршлага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглав.

Түүнчлэн мэдээллийг аргачлалын 3 дугаар зүйлийн 3.7.3.4 дэх дэд заалтад заасан биечилсэн судалгааг хийж хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийж мэдээлэл цуглуулна.

3.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээний хүрээ 1	Цахим гарын үсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг: “1 дүгээр зүйл.Хуулийн зорилт <i>1.1.Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i> 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ <i>3.1.Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.”</i>
Шалгуур	Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар
Шалгуур үзүүлэлтийг томьёолсон байдал	Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр иргэн, хуулийн этгээдийн цахим болон тоон гарын үсгийн хэрэглээ бусад улс орнуудтай харьцуулахад нэмэгдсэн эсэх
Үнэлсэн байдал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.11 дэх заалтад: “хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.” гэж заасан. Цахим гарын үсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан буюу өөрөөр хэлбэл энэхүү хуулиар ямар харилцааг зохицуулах талаар тусгасан хэдий ч энэхүү хуулийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, биелэгдэх зорилгыг тусгайлан шууд заагаагүй байна. Мөн хуулийн 1 дүгээр зүйл дэх томьёоллоос харахад уг хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсэг хэрэглэх этгээдийг тодорхойлоогүй, тухайн этгээдийг таних, баталгаажуулах талаар ямар нэг зорилт дэвшүүлээгүй, ямар зорилгоор цахим болон тоон гарын үсэг хэрэглэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн зорилтыг цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлох гэсэн хэт ерөнхий агуулгаар томьёолж, зөвхөн

	“<i>нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох</i>”-д чиглэгдэж байгаа мэтээр хуулийн зорилтыг тогтоосон нь иргэн, хуулийн этгээд уг хуулийн зорилтоос хуулийн зохицуулалтын хүрээг харахад ихээхэн хүндрэлтэй байдлаар тусгасан байна. Хэдийгээр нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох гэж зорилт дэвшүүлсэн боловч уг хуулийн Тавдугаар бүлэгт энэхүү дэд бүтцэд ямар байгууллагуудыг хамааруулах, эдгээр байгууллага нь ямар чиг үүрэгтэй ажиллах талаар тусгаагүй, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын цахим гарын үсгийн нийтийн түлхүүрүүдийн дэд бүтцийн журмууд”-ын 1.3.1-д Монгол Улсын Нийтийн түлхүүрийн дэд бүтэц нь гэрчилгээ олгох байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хянах эрх бүхий байгууллагын дэргэдэх, Монгол Улсын Үндэсний Гэрчилгээжүүлэх Байгууллага (МУҮГБ – Mongolian National Root CA), Тоон гэрчилгээний үндэсний сан болон Тусгай зөвшөөрөл эзэмшигч Гэрчилгээжүүлэх байгууллага (цаашид ГБ), түүний бүртгэлийн нэгжүүдээс (цаашид БН) бүрдэнэ гэж хуулиар тодорхойлоогүй суурь харилцааг журмаар зохицуулсныг засаж сайжруулах шаарлагатай. Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд тухайлбал, Израйль Улсын Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилго нь цахим хэрэгслийг ашиглан хувь хүнийг баталгаажуулах, гарын үсэг зурсан нотолгоог таних замаар цахим хэлбэрээр, ялангуяа интернэтээр дамжуулан гүйцэтгэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, Бүгд Найрамдах Турк Улсын Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилго нь цахим гарын үсэг хэрэглэх болон цахим гарын үсэгт тавигдах техникийн болон хууль зүйн шаардлагуудыг тодорхойлох, Бүгд Найрамдах Солонгос Улсын Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилго нь цахим гарын үсгийн эрх зүйн үндсийг бий болгох замаар хүмүүсийн амьдралын тав тухыг дээшлүүлэх, цахим мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, цахим гарын үсгийг хэрэглэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна. Уг хуулийн зорилтыг тодорхой бус томъёолсноос сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд уг хуулийн зохицуулалт нь хуулиар тогтоосон зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг дүгнэхэд ихээхэн хүндрэлтэй хэдий ч сонгож авсан зүйл, заалтыг аргачлалын дагуу шалгаж, дүгнэлт өгөх нь зүйтэй юм. Хуулийн үйлчлэх хүрээний хувьд мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж заасан байх бөгөөд албаны нууцад
--	---

	хамаарах мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад энэ хууль үйлчлэхгүй байхаар заасан нь хуулийн үйлчлэх хүрээг ихээхэн хумьсан шинжтэй зохицуулалт үйлчилж байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батлахаар заасны дагуу байгууллагууд албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хэт өргөн хүрээнд гаргах тохиолдол байсаар байгаа нь төрийн байгууллагын хэмжээнд тоон гарын үсэг хэрэглэн дамжуулж болох мэдээ, баримт бичгийг албаны нууцад хамааруулсан гэдэг үндэслэлээр хасаж байна. Нөгөө талаар албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад нууцлал алдагдах эрсдэлээс сэргийлж байгаа гэх боловч гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсэг хэрэглэн цахим орчинд хүн, хуулийн этгээд нь өөрийгөө батлах, цахим өгөгдлийг аюулгүй дамжуулах, хүлээн авах, харилцагч талуудын хооронд итгэлцэл бий болгох, эх сурвалжийг баталгаатай тодорхойлох боломжтой болсныг анхаарах нь зүйтэй. Монгол Улсад тоон гарын үсгийн хэрэглээтэй холбоотой маргаан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэгддэггүй байна.² Өнөөгийн байдлаар мөн Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /shuukh.mn/-аас тоон гарын үсэгтэй холбоотой маргаан хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр олдоогүй. Ерөнхийдөө тоон гарын үсгийг хуурамчаар үйлдэх боломжгүй хамгаалалт сайтай, зурагдсан тоон гарын үсэг болон түүнд хавсаргасан буюу нэгтгэсэн мэдээ, баримт бичигт өөрчлөлт орсон эсэхийг тогтоох боломжтой гэж үздэг байна. Тэгвэл ердийн гарын үсгийг хэн ч дуурайлган зурах боломжтой ба гарын үсгийн тусгай криминалистик шинжилгээгээр дууриалгасан эсэхийг тогтоодог, ихэнх тохиолдолд энэ шинжилгээгээр ч тогтоож чаддаггүй. Энэ тухай мөн “Тридиум э-секьюрити” компанийн ерөнхий захирал Ө.Эсболд “...хувь хүний зурсан ердийн гарын үсгийг хуулбарлан дуурайх асуудал ямагт гарч ирсэн. Харин энэхүү тоон гарын үсгийг ашигласанаар хуулбарлан дуурайх ямар ч боломжийг олгохгүй”³ гэж өгүүлснийг анхаарах нь зүйтэй.
--	--

²А.Мөнхзул, “Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай”, Монголын төр, эрх зүй №1 (2014): 26 дахь тал.

³Ө.Эсболд, “Иргэдэд таатай тоон гарын үсгийн технологийг нэвтрүүлэгч Тридиум э-Секьюрити”, 2018.11.15, <https://ikon.mn/n/1fle>.

Үнэлгээний хүрээ 2	Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг: “6 дугаар зүйл. Тоон гарын үсгийг хэрэглэх <i>6.1. Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх/-ээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох ажиллагааг Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхэлдэг. Тус хуулийн 4.1.8-д “тоон гарын үсгийн гэрчилгээ гэж тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олгосон тоон гарын үсэг эзэмших эрх, тоон гарын үсгийн нийтийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан, баталгаажуулсан цахим баримт бичгийг” ойлгоно гэж заажээ. Цахим гарын үсгийн тухай хуулийн 10.2-т заасан этгээд 10.3-т заасан мэдээллийн үнэн зөвийг шалган 10.4.1-т зааснаар “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэдээлэл үнэн зөв бол гэрчилгээ олгох”, 10.4.2-т зааснаар “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлийн нэгж /цаашид “бүртгэлийн нэгж” гэх/ мэдээлэл үнэн зөв бол тухайн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгуулахаар өргөдлийг хүсэлт гаргагчийн бөглөсөн маягтын хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх”, 10.4.3-т зааснаар “хүсэлт гаргагчийн мэдээлэл нь буруу, зөрүүтэй бол өргөдлийг хүсэлт гаргагчид буцаах” зэрэг шийдвэрүүдийн аль нэгийг гаргадаг. Монгол Улсад ердийн гарын үсэг хэрхэн хэрэглэх тухай хуулийн зохицуулалт байхгүй.⁴ Кембрижийн толь бичигт гарын үсгийг “ихэвчлэн тухайн этгээд ямар нэг зүйлийг бичсэн эсвэл хүлээн зөвшөөрснийг илэрхийлж өөрийн гараар давтагдашгүй нэг хэвээр бичсэн түүний нэр”⁵ гэж тодорхойлсон. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх/-ээс олгосон тоон гарын

⁴ А.Мөнхзул, “Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай”, Монголын төр, эрх зүй №1 (2014): 25-27 дахь тал.

⁵ <https://dictionary.cambridge.org/dictionary/english/signature>

	үсгийн гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцно” гэж заасан тул тухайн этгээд тоон гарын үсэг хэрэглэснээр ердийн гарын үсгийн адил өөрийг нь таньж болох, дахин давтагдахгүй баталгаажуулалтыг цахим орчинд хийсэнд тооцдог болсон. Энэхүү эрх зүйн үр дагавар үүсч буйг Цахим гарын үсгийн тухай хуулийн 10.5.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол тоон гарын үсгийг хэрэглэснээр ердийн гарын үсгийг хэрэглэсэнтэй адил эрх зүйн үр дагавар үүсэх ...” гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоон гарын үсгийн гэрчилгээ авч буй этгээдэд таниулах үүрэгтэй байдаг. Тоон гарын үсэг хэрэглэхтэй холбоотой дээр дурдсан суурь зохицуулалтуудыг Цахим гарын үсгийн тухай хуульд тусгаснаар уг хуулиар тогтоосон цахим гарын үсгийн эрх зүйн үндсийг тогтоох зорилтод хүрсэн гэж үзэхээр байгаа хэдий ч бусад улс орнуудын хувьд тоон гарын үсэгт тавигдах шаардлагыг тодорхой хуульчилсан байдгийг уг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна. Жишээ дурдвал, Бүгд Найрамдах Солонгос Улсын Цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсэг бий болгох хувийн түлхүүрийг зөвхөн гарын үсэг зурсан хүн мэддэг байх, гарын үсэг зурагч гарын үсэг зурах үед түлхүүрийг хянаж удирдах боломжтой, тоон гарын үсгийг олгосноос хойш өөрчлөлт орсон эсэхийг тодорхойлох боломжтой, тоон гарын үсэг олгосноос хойш цахим баримт бичигт өөрчлөлт орсон эсэхийг тодорхойлох боломжтой байх зэрэг шаардлагууд тавигддаг байна. Европын холбооны 1999 онд “Цахим гарын үсгийн удирдамж”-ийг баталж, 2014 онд зохицуулалтыг шинэчлэн, 2016 оноос холбооны бүх улсуудад хэрэгжиж эхэлсэн “Цахимаар таних болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS No 910/2014)-ын зохицуулалтаар ЕХ-ны уг журам нь цахим гарын үсгийг зөвхөн цахим хэлбэрт байгаа, эсхүл шаардлага хангасан цахим гарын үсгийн шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр шүүх хуралдаанд нотлох баримт болгон хууль ёсны хүчин төгөлдөр болох, хүлээн зөвшөөрөхөөс татгалзадаггүй ба шаардлагад нийцсэн цахим гарын үсэг нь бичмэл гарын үсэгтэй адилтгах хууль эрх зүйн хүчин төгөлдөр байдаг байна. Түүнчлэн нэг гишүүн улсад олгосон шаардлагад нийцсэн цахим гарын үсгийг бусад бүх ЕХ-ны гишүүн улсад шаардлагад нийцсэн цахим гарын үсэг гэж хүлээн зөвшөөрдөг байна. Тоон гарын үсэг хэрэглэхтэй холбоотой Цахим гарын үсгийн тухай хуулийн зохицуулалтаар тоон гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хүчинтэйд тооцохоор заасан хэдий ч цахим болон тоон гарын үсэг хэрэглэн цахим хэлбэрээр дамжуулсан мэдээ, баримт бичгийг нотлох баримтаар үнэлэх асуудал хэрэг хянан шийдвэрлэх хуулиар хангалттай хэмжээнд зохицуулагдаагүйгээс хууль ёсны хүчин төгөлдөр байдлыг
--	---

	хүлээн зөвшөөрөхөд ихээхэн хүндрэлтэй байдгийг анхаарах шаардлагатай. Түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд цахим баримт бичгийг бусдад шилжүүлэх, дамжуулахдаа зөвхөн тоон гарын үсэг хэрэглэнэ.” хэмээн зааж өгсөн хэдий ч Архивын ерөнхий газрын даргын баталсан Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврийн 3.6.2-т цахим баримтыг дамжуулах, хүлээн авах ажиллагааг журамлахдаа “тусгай зөөгч дээрх баримтыг өөр байгууллагад явуулахдаа албан бичгээр дагалдуулна”, “гаднаас ирсэн цахим баримтыг хүлээн авч, бүртгэх, танилцуулах журам цаасан баримтынхтай ижил байна”, “цахим шуудангаар хүлээн авсан баримтыг принтерээр хэвлэн, бичиг хэрэгт хүлээн авсан тухайг нотолж, бүртгэлийн тэмдэг дарна. Мөн цаасан дээрх хувь нь цахим эх баримттай адил хүчинтэй болохыг бичиг хэргийн ажилтан баталж, гарын үсэг, он, сар, өдөр тавина”⁶ гэж цахим албан баримт илгээхдээ цахим гарын үсгээр бус албан бичиг дагалдуулан илгээж баталгаажуулахаар тусгаж, хуулиас давсан зөрчилтэй байж болох заалтууд журамд байсаар байна. Энэ нь цахим гарын үсэг, тоон гарын үсгийн хэрэглээ удаашрах, хууль практикт нийцэж хэрэгжихгүй байх нэг нөхцөл болж байна.
--	---

Үнэлгээний хүрээ 3	Цахим гарын үсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг: <i>“7 дугаар зүйл. Тоон гарын үсгийн хэрэгсэл</i> <i>7.1.Тоон гарын үсэг тухайн тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч этгээдэд хамаарах эсэх болон тухайн цахим баримт бичиг бүрэн бүтэн эсэхийг тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглан шалгана.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох

⁶ Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тогтоол, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, <https://www.legalinfo.mn/annex/details/6555>.

Үнэлсэн байдал	Цахим гарын үсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Тоон гарын үсэг тухайн тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч этгээдэд хамаарах эсэх болон тухайн цахим баримт бичиг бүрэн бүтэн эсэхийг тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглан шалгана.” гэж заан, тоон гарын үсэг бүхий цахим баримт бичгийн агуулгад өөрчлөлт орсон эсэхийг тогтоох боломжтой, тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийг таних боломжтой, тоон гарын үсгийг хуурамчаар үйлдсэн эсэхийг тогтоох боломжтой, хувийн түлхүүрийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх нөхцөлийг хангасан, хувийн түлхүүр болон тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийг үүсгэх, дамжуулахдаа түүний давтагдашгүй байдал болон нууцлалыг хангасан байх гэсэн шаардлагыг тоон гарын үсгийн хэрэгсэлд тавьж байна. Уг хуульд заасан эдгээр зохицуулалтаас харахад иргэн, хуулийн этгээдэд олгох тоон гарын үсгийн ямар мэдээллийг тоон гарын үсгийн хэрэгсэлд байршуулах талаар тодорхой дурдаагүйн дээр тоон гарын үсэг болон тоон гарын үсгийн хэрэгсэлд тавигдах шаардлага хооронд ямар нэгэн ялгаа тогтоогоогүй томъёоллыг хийсэн байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэлд тоон гарын үсгийг хавсаргасан, эсхүл нэгтгэсний дараа мэдээлэл болон тоон гарын үсэгт өөрчлөлт оруулсан, мэдээллийн бүрэн бүтэн эсэхийг мэдэх боломжтой, тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийг нийтийн түлхүүр ашиглан таних, шалгах боломжтой зэрэг нь тоон гарын үсэгт тавигдах шаардлага бөгөөд хуульд тоон гарын үсгийн хэрэгсэлд тавигдах шаардлагаар тогтоосон байна. Гадаадын улс орнууд тоон гарын үсгийн хэрэгсэлд юуг хамааруулж байгаа талаар тодруулья. Эстони улсын иргэд тоон гарын үсгийг ашиглахад өөрт тохиромжтой аргыг сонгож болно. Одоогийн байдлаар нийтлэг дөрвөн арга байдаг. Үүнд: • Эстони улсын иргэнд зайлшгүй байр шаардлагатай баримт бичиг болох иргэний үнэмлэх. Цахим гарын үсэг зурахад шаардагдах ПИН нь картын хамт хамгаалалттай дугтуйнд тусгаж олгогдоно. Иргэний үнэмлэхээ ашиглахын тулд карт уншигч, мөн иргэний үнэмлэхний програм хангамж суулгах шаардлагатай. Иргэний үнэмлэхний одоогийн ашиглаж буй чип дээр илүү олон алгоритмуудыг идэвхжүүлэх тул Java аппликейшний тусламжтай дахин хялбар байдлаар програмчлах боломжтой. Шинэ аппликейшнийг зөвхөн Цагдаагийн газар эсвэл Хил хамгаалах байгууллага (RSA2048 ашиглан SSL/TLS холболтыг үүсгэх) дээр суулгах боломжтой ба 1 үнэмлэх дээр 5-7 минутыг зарцуулна. Тоон гарын үсэг ба баталгаажуулалтын хувийн түлхүүрүүдийг иргэний үнэмлэх дотор чип доторх санамсаргүй тоон үүсгэгч ашиглан бий болгодог бөгөөд
------------------------------	---

	энэ нь чип доторх санамсаргүй физик процессоос шаардлагатай хэмжээний энтропийг олж авч баталгаажуулдаг. Үйлдвэрээс гарсан чипүүдийг Цагдаагийн газар, Хилийн хамгаалах газраас ирүүлсэн зааврын дагуу өөрчилж, шаардлагатай RSA түлхүүрүүдийг картын дотор үүсгэдэг. Энэ процедур нь нэг картанд 5 минут хүртэл хугацаа шаардагдана. • Digi-ID үнэмлэх: Эстони улсын иргэд Digi-ID-гаа иргэний үнэмлэхтэй хамтад нь ашиглаж болох бөгөөд гадаадын иргэдэд цахим оршин суугчийн тоон үнэмлэхийг олгодог. • Mobile-ID нь гар утсаа ашиглан цахим зөвшөөрөл болон тоон гарын үсгийг зурахад зориулагдсан SIM картанд суурилсан шийдэл юм. Mobile-ID SIM картыг үүрэн холбооны операторууд гаргадаг. • Smart-ID нь ухаалаг гар утсанд зориулсан SIM-ээс үл хамаарах төхөөрөмжид суурилсан шийдэл юм. Эстони улсын иргэд цахим гарын үсгийн хэд хэдэн гэрчилгээ авах боломжтой. (Жишээлбэл иргэний үнэмлэх-1, хэд хэдэн Digi-ID болон Mobile-ID ашиглаж болно) Тоон гарын үсгийн хэрэгсэл нь хувийн түлхүүрийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн, хувийн түлхүүр болон нийтийн түлхүүрийг үүсгэх, дамжуулахдаа түүний давтагдашгүй байдал болон нууцлалыг хангасан байх шаардлагатайг хуульд тодруулж өгөх нь зүйтэй.
--	--

Үнэлгээний хүрээ 4	Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг: “8 дугаар зүйл. Тамга орлуулах <i>8.1. Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Монгол Улсын стандарт “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS5140-2:2011” ⁷ -ын 5.1-т “баримт бичгийг зохион бүрдүүлж, албан ёсны болгоход

⁷ Стандарт, хэмжил зүйн газар, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага, <http://estandard.gov.mn/standart/reader/412> (Сүүлд үзсэн огноо: 2020.05.15).

	тамга, тэмдэг ашиглах”, 6.19-т “байгууллагын удирдах албан тушаалтны гарын үсэг болон баримт бичгийн хуулийн хүчинтэй эх болохыг баталгаажуулж, тамга, тэмдэг дарна. Зохион байгуулалтын нэгжийн дарга гарын үсэг зурсан баримт бичигт тэмдэг дарна” гэж заажээ. Мөн Архивын ерөнхий газрын даргын 2009 он 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.3.12-т “Баримт бичгийн албан ёсны хүчин төгөлдөр байдал болон албан тушаалтны гарын үсгийг тамга, тэмдэг дарж, баталгаажуулна. Байгууллагын тамгыг дарга, орлогчийн, байгууллагын тэмдгийг зохион байгуулалтын нэгжийн даргын гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна”⁸ гэж заасан. Харин тамга, тэмдэг хэрэглэх зааврыг Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг тогтоолын хавсралтын 32 дугаар зүйлд “ям, засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, түүнчлэн үйл ажиллагаа нь хуулиар буюу Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогддог төрийн байгууллага, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын тамгыг сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, дарга, дэд дарга; тэмдгийг газар, хэлтэс, тасаг, албаны дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна”⁹, 33 дугаар зүйлд “Бүх шатны Засаг даргын тамга, тэмдгийг Засаг дарга, тэдгээрийн орлогч, хот, тосгоны захирагчийн тамга, тэмдгийг хот, тосгоны захирагч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамгыг Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Нарийн бичгийн дарга, Иргэдийн Нийтийн Хурлын тамгыг Хурлын Тэргүүлэгчдийн даргын гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна” гэж заажээ. Тэгэхээр баримт бичиг дээр дарсан тамга, тэмдэг нь баримт бичгийн бүрдэл хэсэг бөгөөд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсныг тамга эсвэл тэмдэг дарж баталгаажуулдаг байна. Цаасан суурьтай баримт бичгийг баталгаажуулахад хэрэглэдэг эдгээр бүрдлийг цахим баримт бичиг баталгаажуулалтад ашиглах ёстойг цахим гарын үсгийн тухай хууль болон төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журамд тус тус тусгасан. Тухайлбал, Цахим гарын үсгийн тухай хуулийн 8.1-д “Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ” гэж заасан
--	---

⁸ Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тогтоол, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай, <https://www.legalinfo.mn/annex/details/6555>.

⁹ Засгийн Газрын 2001 оны 41 дүгээр тогтоол, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, <https://www.legalinfo.mn/annex/details/1086?lawid=2822>.

	бол Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журмын 4.7-д “цахим баримт бичиг нь тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсэг болон тамга, тэмдэг дарж баталгаажуулах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажна”¹⁰ гэж заасан. Тэгэхээр төрийн байгууллага албан баримт бичиг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахдаа эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр болон тамга түших эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулах ёстой байна. Гэхдээ Цахим гарын үсгийн тухай хуулийн 8.1-д “Тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6.2, 6.5-д заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ” гэж зааснаас харахад энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 болон 6.5 дахь хэсэгт заасан тоон гарын үсгийг эрх бүхий албан тушаалтанд олгосон тоон гарын үсэг гэж ойлгож байна. Гэтэл тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно” гэж заасан бол мөн зүйлийн 6.5 дахь хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болсонд тооцсон байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн гэдгийг эрх бүхий албан тушаалтан гэж ойлгохгүй ба мөн хүчингүй болсон заалтыг агуулсан тул энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг нийгэм хүлээн зөвшөөрч, ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч байна. Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулах /хүлээн авах/ тохиолдолд энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дахь хэсэгт заасан тоон гарын үсгээс гадна тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг давхар хэрэглэнэ” гэж заасан нь тухайн цахим баримт бичгийг 2 албан тушаалтан өөрсдийн тоон гарын үсгээрээ баталгаажуулах шаардлагыг тавьсан байна. Өөрөөр хэлбэл, хоёр дахь этгээдийн тоон гарын үсгийг тухайн баримт бичигт дарсан тамга гэж ойлгох ёстой болж байна. Тамга дарсан буюу тамга дарах ёстой баримт бичигт тамгыг хэрхэн орлуулдаг тухай олон улсын зохицуулалтыг авч үзье.
--	---

¹⁰ Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоол, Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, <https://www.legalinfo.mn/annex/details/7761?lawid=12581>.

	Европын холбооны 2014 оны 910 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 25 дахь хэсэгт “цахим тамга гэж эцсийн байдлаар гарал үүсэл болон бүрдэлийг батлах цахим хэлбэрийн өгөгдөлд хавсаргасан эсвэл логик хамааралтай цахим өгөгдлийг хэлнэ”¹¹ гэж тодорхойлсон ба Тавдугаар бүлэгт цахим тамганы тухай зохицуулалтуудыг тусгасан байна. Үүнээс үзэхэд цахим тамга нь тоон гарын үсгийн адил баримт бичгийг шифрлэж хамгаалдаг боловч зарчмын хувьд ялгаатай байдаг байна. Өөрөөр хэлбэл, цахим тамгыг тоон гарын үсгээс ялгаж нэрлэж буй нь баримт бичиг баталгаажуулах процесс болон үүний эзэмшигчээс шалтгаалсан байна. Тухайлбал, нууцлалын архитектор Жон Эрик тайлбарлахдаа “тоон гарын үсгийг цахим баримт бичигт зурахдаа албан тушаалтан зөвхөн өөрийн биеэр төхөөрөмж, нууц үгээ ашигладаг бол цахим тамгыг дарахад байгууллагын төхөөрөмж, нууц үгийг ашигладаг”¹² гэжээ. Мөн цахим тамга дарах ажиллагааг хүний оролцоогүйгээр баримт бичиг боловсруулах программ хангамжид нэгтгэх байдлаар автоматжуулж ашиглах боломжтой юм. Иймд одоогийн тамга оруулах зохицуулалтыг өөрчилж, илүү ойлгомжтой болгох шаардлагын үүднээс эзэмшигч этгээдийг тодорхой болгож, цахим тамга хэрэглэхтэй холбоотой асуудлыг хуульд тодорхой зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.
--	--

Үнэлгээний хүрээ 5	Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг: “10 дугаар зүйл. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох 10.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 34.1.5-д заасан журмын дагуу хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/ олгож болно. 17 дугаар зүйл.Гадаад улсын тоон гарын үсгийн гэрчилгээ 17.1.Гадаад улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон гэрчилгээг Монгол Улсад ашиглаж болно.”
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх

¹¹ European Union. “Regulation (EU) no 910/2014”. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2014.257.01.0073.01.ENG (Сүүлд үзсэн огноо: 2020.05.12).

¹² John Erik Setsaas, Introduction to digital seals, 2016. <https://web.archive.org/web/20180114234339/https://www.signicat.com/blog/blog-introduction-digital-seals/> (Сүүлд үзсэн огноо: 2020.5.12).

Шалгуур үзүүлэлтийг томьёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгохоор заасан байдаг. Гэтэл энэ хүрээнд иргэн, хуулийн этгээд тоон гарын үсгийн гэрчилгээ авахдаа хүсэлтийг хэрхэн гаргах, хүсэлтэд ямар мэдээлэл тусгах, хүсэлтийг хүлээн авсны дараа хэрхэн шийдвэрлэх харилцааг цогц байдлаар хуульд зохицуулаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх гэсэн шаардлагад нийцээгүй байгааг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хуулиар иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгохдоо гадаадын иргэнд тоон гарын үсэг олгох эсэх асуудлыг бүрхэг орхигдуулсан байгааг шийдвэрлэх хэрэгтэй. Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Гадаад улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон гэрчилгээг Монгол Улсад ашиглаж болно.” гэж заасан хэдий ч ямар тохиолдолд гадаад улсын тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байгааг тодруулах шаардлагатай юм. Эстони Улс, Бүгд Найрамдах Турк Улсын туршлагаас харахад гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллага нь энэ хууль, холбогдох журамд заасан шаардлагыг хангаж байгаа талаар эрх бүхий байгууллага шийдвэр гаргасан, эсхүл тухайн улстай байгуулсан олон улсын гэрээгээр гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллагын гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн зэрэг үндэслэлээр гадаад улсын гэрчилгээг хүлээн зөвшөөрч байна.

Үнэлгээний хүрээ 6	Цахим гарын үсгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг: <i>“12 дугаар зүйл. Гэрчилгээний хугацаа 12.1. Гэрчилгээг 2 хүртэл жилийн хугацаагаар олгоно.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томьёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох

Үнэлсэн байдал	Цахим гарын үсгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох тоон гарын үсгийн гэрчилгээний хугацааг 2 хүртэл жилийн хугацаагаар олгохоор тогтоожээ. Уг хугацааг тогтоохдоо иргэн, хуулийн этгээдэд олгох гэрчилгээний хугацаанд ямар нэгэн ялгаа тогтоогоогүй, мөн хугацаа 2 хүртэл жил байхаар тогтоосноор тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд хугацааг ихдээ 2 жилийн хугацаагаар олгож, тэр бүртээ гэрчилгээний үнэ буюу тоон гарын үсэг болон тоон гарын үсгийн хэрэгсэл, үйлчилгээний хөлс авах нөхцөл бүрдэхээр байна. Иймд хугацааг иргэн, хуулийн этгээдэд илүү ялгамжтай, хугацааг боломжит урт хугацаагаар тогтоох шаардлагатай юм. Эстони Улсад цахим гарын үсгийн гэрчилгээг 3 жилээр олгодог байсныг 2019 оноос 5 жилийн хугацаатай олгодог болсон байна. Тоон гарын үсэгт ашиглах картын хугацаа 5 жилийн хүчинтэй байх бөгөөд хугацаа дууссан тохиолдолд шинээр түлхүүр үүсгэн авах боломжтой байдаг байна. Түүнчлэн гадаад иргэнд тоон гарын үсэг олгох асуудлыг хуулиар зохицуулахаар бол түүнд оршин суух хугацаатай нь уялдуулан тоон гарын үсэг олгох нь зүйтэй юм.
-----------------------	--

Үнэлгээний хүрээ 7	Цахим гарын үсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг: <i>“13 дугаар зүйл. Гэрчилгээг түдгэлзүүлэх</i> <i>13.1. Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.”</i>
Шалгуур	Практикт нийцэж байгаа байдал
Харьцуулах хэлбэр	Тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх
Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлох
Үнэлсэн байдал	Цахим гарын үсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоон гарын үсгийн гэрчилгээг олгож, уг гэрчилгээг түдгэлзүүлэх үндэслэлийг тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заахдаа “Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.” гэж заажээ. Энэ заалтад илэрсэн зөрчлийн талаар тодорхой заагаагүй тул тоон гарын үсгийн гэрчилгээ олгох

	тусгай компаниуд гэрчилгээжүүлэх бодлого/гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу зөрчил илэрсэн, илрээгүйгээс үл хамааран тоон гарын үсгийн гэрчилгээг гэрчилгээ эзэмшигчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу түдгэлзүүлж байна. Тэгвэл гэрчилгээг түдгэлзүүлэх асуудлыг гадаад улс орнууд хэрхэн зохицуулж байгааг судалж үзье. Эстони, Израйль, Турк зэрэг улс орнууд гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан, гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, эсхүл хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж гэрчилгээжүүлэх байгууллага үзсэн, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчилгээг түдгэлзүүлэх талаар шийдвэр гарсан зэрэг үндэслэлээр түдгэлзүүлж, гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээг түдгэлзүүлсэн тухай гэрчилгээ эзэмшигчид даруй мэдэгдэх талаар үүрэг хүлээлгэдэг байна. Түүнчлэн гэрчилгээг сэргээх талаар тусгахдаа түдгэлзүүлсэн үндэслэлээс шалтгаалан өөр өөр нөхцөлөөр сэргээдэг байна. Тухайлбал, гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг сэргээх тухай хүсэлт гаргаснаар гэрчилгээг сэргээх, гэрчилгээг гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, эсхүл хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж гэрчилгээжүүлэх байгууллага үзсэн, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчилгээг түдгэлзүүлэх талаар шийдвэр гарсан зэрэг үндэслэлээр түдгэлзүүлсэн бол энэхүү түдгэлзүүлсэн шалтгаан арилсан тохиолдолд гэрчилгээжүүлэх байгууллага сэргээхээр ялгамжтай байдлаар зохицуулсныг анхаарах шаардлагатай.
--	---

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- 1.Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилтыг тухайн хуулиар зохицуулж байгаа харилцааны цар хүрээнд нийцүүлэн өргөн хүрээтэй болгох асуудлыг шийдвэрлэх;
- 2.Хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрийн орны онцлогт тохируулан өөрчлөх;
- 3.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгах;
- 4.Давхардсан болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж буй заалтуудыг өөрчлөн найруулах, нийцүүлэх;
- 5.Хуулиас дээгүүр болзол, шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж, журмаар зохицуулж байгаа суурь харилцааг хуульд тусгах зэрэг болно.

---oOo---